



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/143

Хөхбүрд

Үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, “Ургамал хамгааллын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.7, Гамшигийн тухай хуулийн 32.1.7, 32.1.9, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ны А/143 дугаар тушаал, Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/205 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрт хөнөөл учруулж буй мэрэгчтэй (үлийн цагаан огтоно, чичүүл гэх мэт) Микробиологийн аргаар тэмцэх ажлыг орон нутагт хариуцан зохион байгуулж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичиг: Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Гишүүд: Ж.Ёндонпил (Мал эмнэлгийн тасгийн дарга)

П.Мөнхтогоо (БОХУлсын байцаагч)

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Энхмөнх (Жолооч)

2. Ажлын хэсэг нь 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд Асгамба 3 дугаар багийн Үүд, Бэлчирийн хоолой, Агт, Мэргэн 4 дүгээр багийн Элст толгой, Антений нуруу, Байц, Занги нийт нутаг дэвсгэрт нийт 18 га үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг зохион байгуулсугай.

3.Үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг зохион байгуулахдаа малчид, иргэдийн идэвх, оролцоонд тулгуурлах, тэмцэх ажлыг богино хугацаанд их талбайг хамруулан үр дүнтэй зохион байгуулахад шаардагдах хүн хүчний нөөцийг бүрдүүлэх малчид, иргэдэд сургалт сурталчилгаа хийх, мэрэгч амьтны нягтралын тоог нарийвчлан гаргах, тэдэнтэй гэрээ байгуулан, талбайг хэмжин өгч ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

642301057

4. Багийн Засаг нартай гэрээ байгуулах, тэмцэх талбайг хувиарлах, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэнд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Л.Гүндцамба)-д хариуцуулсугай.

5. Гамшигийн зардлаас авах бактержуулсан будааны зардал болох 10.000.000 (Арван сая) төгрөг болон бусад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Л.Алимаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР